

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.02.26-03.02

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ 7 хоногт АНУ-ын компаниудын хувьцааны үнэ огцом уналттай байв. S&P 500 Индексийн мэдээлэл технологи болон өргөн хэрэглээний барааны компаниудын хувьцаа хамгийн өндөр үзүүлэлттэй байсан бол аж үйлдвэрийн болон бизнесийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын хувьцаа хамгийн их буурсан байна. Томоохон аж үйлдвэрийн компани болох "Катерпиллар"-ийн хувьцааны уналт Доу Жонсын Индексийн уналтад хамгийн их нөлөөг үзүүлсэн бол харьцангуй бага зах зээлийн үнэлгээтэй, технологид суурилсан Nasdaq Индекс харьцангуй тогтвортой үзүүлэлттэй байлаа.

АНУ-ын Ерөнхийлөгчийн ган, хөнгөн цагааны импортод гаалийн тариф тогтоох шийдвэр бондын зах зээлд огцом нөлөө үзүүлсэн нь анхаарал их татаж байна. АНУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны ханш 7 хоногийн турш буурсны эцэст АНУ-ын Ерөнхийлөгчийн шийдвэрийн дараа өсжээ. Ган, хөнгөн цагааны үнэ нэмэгдсэнээр бусад барааны үнэ өсөж, инфляцийн түвшин нэмэгдэх магадлал өндөр байгаа гэж шинжээчид үзэж байна.

Канад: Канадын гол хувьцааны индекс энэ Баасан гарагт сүүлийн 2 долоо хоногийн хамгийн доод түвшинд хүрч, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1,6 хувиар буурсан байна. S&P/TSX Индекс 9.36 нэгж буюу 0.06 хувиар буурч 15,384.59-д хүрсэн нь 2-р сарын 14-нөөс хойшхи хамгийн доод түвшин юм.

Европ: АНУ-ын Ерөнхийлөгчийн шийдвэрийн дараа энэ 7 хоногт Европын хувьцаанууд бага хэмжээгээр арилжигдаж, хувьцаануудын үнэ буурсан байна. Европын STOXX 600 болон Германы DAX 30 Индексүүд 1 орчим хувиар унасан бол Английн цэнхэр хясаа болох FTSE 100 Индекс 2.41 хувиар буурсан байна. Их Британий Ерөнхий Сайд Тереза Мэй Европын Холбооны Brexit хэлэлцээрийн төслөөс татгалзсанаас хойш FTSE 100 Индексийн хувьцаануудын ханш суларсан билээ.

Япон: Японы хувьцаанууд 7 хоногийн эхээр бага зэргийн өсөлттэй байсан боловч АНУ-ын бодлогын хүү болон ам. долларын ханш чангарсантай холбогдуулан уналтанд орсон. Энэ 7 хоногт гол Nikkei 225 Индекс өнгөрсөн 7 хоногоос 3.25 хувиар (711 нэгжээр) буурч 21,181.64 нэгж болж хаагдсан. Nikkei 225 Индекс 2018 оны эхээс 6.95 хувиар (1,583 нэгжээр) буурсан үзүүлэлттэй байна. Японы иен ам. долларын эсрэг өнгөрсөн 7 хоногийн түвшнээс 1.08 хувиар өсөж 105.41 хүрсэн ба 2018 онд иен ам. долларын эсрэг 6.34 хувиар буурсан.

Мөн Японы зах зээлд голлох нөлөөг АНУ-ын Ерөнхийлөгчийн шийдвэр үзүүлсэн билээ. Ган, хөнгөн цагааны салбар японы авто машин үйлдвэрлэгчдийн анхаарлыг хамгийн их татдаг салбар юм. АНУ-д нийлүүлдэг япон авто машины дийлэнх хувийг АНУ-ын ган, хөнгөн цагаанаар тус улсад угсардаг хэдий ч, АНУ-ын гаалийн тариф зарим түүхий эдийн үнийг өсгөн, машин үйлдвэрлэгчдэд дарамт учруулж болзошгүй байна.

Эх сурвалж: Reuters.com, Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Mongolia	19,615.58	-3.12% ▼
Dow Jones	USA	24,538.06	-3.05% ▼
S&P 500	USA	2,691.25	-2.04% ▼
Nasdaq	USA	7,257.87	-1.08% ▼
S&P/TSX	China	15,384.59	-1.62% ▼
FTSE 100	GB	7,069.90	-2.41% ▼
S&P/ASX 200	Australia	5,928.90	-1.18% ▼
Nikkei 225	Japan	21,181.64	-3.25% ▼
Hang Seng	Hong Kong	30,583.45	-2.19% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	114.05
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	99.91
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	98.74
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	116.83
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.48
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.83
TDBM' 2020	USD	9.3%	108.80

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.691	0.06 ▲
Libor 3M	2.025	0.07 ▲
Libor 6M	2.228	0.05 ▲
Libor 1YR	2.497	0.04 ▲
US 6M Bond	1.831	-0.01 ▼
US 2YR Bond	2.222	-0.01 ▼
US 3YR Bond	2.368	-0.01 ▼
US 5YR Bond	2.598	-0.01 ▼
US 10YR Bond	2.839	-0.02 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.03.02	Өөрчлөлт
USD	2,393.75	-0.16% ▼
CNY	376.96	-0.34% ▼
EUR	2,936.05	-0.40% ▼
RUB	42.26	-0.33% ▼
KRW	2.22	0.00%
JPY	22.64	0.98% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,322.17	-0.50% ▼
Мөнгө /spot/	16.49	0.28% ▲
Зэс	3.1010	-3.35% ▼
Нүүрс	102.90	-3.35% ▼
WTI газрын тос	61.25	-3.62% ▼
Brent газрын тос	64.37	-4.37% ▼
Байгалийн хий	2.70	2.67% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018.1	6.90%
Монголбанкны бодлогын хүү	2018.1	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.1	13.63%
Хадгаламжийн дундаж хүү /төг/	2018.1	12.50%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.1	5.80%
Зээлийн дундаж хүү /төг/	2018.1	19.40%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.1	10.80%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр нийт 97 компанийн 612,679 ширхэг хувьцаа, 584,636,717 төгрөгөөр арилжаалагдсан байна.

“Евроазиа Капитал Холдинг” /SUN/ компанийн хувьцаа 32.19%-аар буюу хамгийн ихээр өсч 505 төгрөгт хүрч хаагдсан бол “Шарын гол” /SHG/ компанийн хувьцаа 16.99%-иар буурч 2,160.06 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн 2-р сарын 26-с 3-р сарын 02-ны хооронд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлд арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн нийт 14 удаагийн хэлцлээр 10,073 ширхэг үнэт цаас 1,050.5 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр энэ долоо хоногт арилжаа хийгдээгүй байна.


3-р сарын 02-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,361 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,615.58 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 3.12%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны бүтэц / арилжигдсан ширхэгээр /



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /төг/
Арилжигдсан үнийн дүн	1,635,201,757
Зах зээлийн үнэлгээ	2,361,274,011,509

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20*	19,615.58	-3.12% ▼
MSE I индекс	9,510.62	-6.30% ▼
MSE II индекс	9768.08	0.05% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Таван Толгой	30,444	296,458,820
АПУ	167,685	111,206,456
Говь	2,005	45,859,860
Монгол Шуудан	32,704	17,867,323
Айтүүлс	139,250	17,066,570

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Евроазиа Капитал Холдинг	505.00	32.19% ▲
Дархан Зочид Буудал	132.00	32.00% ▲
Эрдэнэт Авто Зам	1,100.00	19.57% ▲
Авто зам	4,710.00	17.72% ▲
Монгол Шилтгээн	464.08	16.02% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Шарын Гол	2,160.06	-16.99% ▼
Мерекс	32.00	-14.83% ▼
Таван Толгой	9,530.00	-13.28% ▼
Айтүүлс	121.44	-9.43% ▼
Тээвэр Дархан	11,500.00	-7.93% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек ХК	436,025,403
Лайфтайм инвестмент ХХК	141,517,284
Голомт Капитал ХХК	125,643,905
Бумбат-Алтай ХХК	79,891,300
Стандарт инвестмент ХХК	71,427,248

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	648.19	689,791
Таван толгой	9,530.00	501,899
МИК	10,000.00	207,093
Говь	22,580.00	176,149
Сүү	219.89	75,642

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Үнэ /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Үнэ /төг/	7 хоног	Хүү
1	ZBEG-BD-09/05/19-A0242-15.995	230	23,450,800	101,960	104	15.995
2	ZBEG-BD-09/05/19-A0242-15.995	99	10,068,300	101,700	104	15.995
3	ZBEG-BD-18/07/20-A0275-15.14	400	40,480,000	101,200	156	15.140
4	ZBEG-BD-11/04/19-A0230-18	1,742	181,969,320	104,460	104	18.000
5	ZBEG-BD-11/04/19-A0230-18	1,742	186,568,200	107,100	104	18.000
6	ZBEG-BD-20/06/20-A0260-15.14	760	78,356,000	103,100	156	15.140
7	ZBEG-BD-20/06/20-A0260-15.14	760	81,418,800	107,130	156	15.140
8	ZBEG-BD-25/04/20-A0236-16.993	479	50,908,120	106,280	156	16.993
9	ZBEG-BD-25/04/20-A0236-16.993	479	52,761,850	110,150	156	16.993
10	ZBEG-BD-27/03/20-A0225-18	500	53,940,000	107,880	156	18.000
11	ZBEG-BD-27/03/20-A0225-18	500	55,830,000	111,660	156	18.000
12	ZBEG-BL-24/04/18-A0235-0	1,141	112,023,380	98,180	52	16.081
13	ZBEG-BL-24/04/18-A0235-0	1,141	112,354,270	98,470	52	16.081
14	ZBEG-BD-22/05/20-A0248-15.87	100	10,436,000	104,360	156	15.870

Компанийн бондын арилжаа / хоёрдогч зах зээл /

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан дүн	Үнийн дүн /төг/	Үнэ /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Нийт ногдол ашиг /сая төг/	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	AEL	Анд-Энерги ХК	13.3	0.5	2018.02.24	2018.03.16	N/A
2	GTL	Гутал ХК	2,055.7	1,270.0	2018.02.19	N/A	2018.07.06-аас
3	BNG	Баянгол Зочид буудал ХК	150.2	355.0	2018.02.19	N/A	2018.09.01-ээс
4	APU	АПУ ХК	10,641.8	10.0	2018.02.19	N/A	2018.06.01-ий дотор
5	BTG	Баянтээг ХК	25.3	100.0	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ий дотор
6	MIE	Материалимпекс ХК	13.7	10.0	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ий дотор
7	MNP	Монгол шуудан ХК	273.5	2.7	2018.02.13	N/A	2018.05.01-ээс
8	MMX	Махимпекс ХК	380.1	100.0	2018.02.13	2018.04.05	2018.10.01-ээс
9	TCK	Талх чихэр ХК	174.0	170.0	2018.02.12	2018.04.06	2018.07.01-ээс
10	ADL	Адуун чулуун ХК	409.7	130.0	2018.02.07	2018.03.01	N/A
11	ТАН	Тахь-ко ХК	128.1	108.0	2018.02.05	N/A	2018.05.01-ий дотор
12	UBH	Улаанбаатар хивс ХК	40.5	100.0	2018.02.05	2018.02.26	2018.05.01-ээс
13	GOV	Говь ХК	1,716.2	220.0	2018.02.02	N/A	2018.04.24-өөс
14	HRM	Гермес центр ХК	392.7	5.0	2018.01.24	2018.02.15	2018.03.06-аас

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Баянгол зочид буудал” компанийн борлуулалтын орлого 2017 онд 14.5 хувиар өсжээ

14.2 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй “Баянгол зочид буудал” компанийн борлуулалтын орлого 2017 онд 14.5 хувиар өсөж, 6.4 тэрбум төгрөг болсон байна. Харин тус компанийн тайлант үеийн цэвэр ашиг жилийн дүнгээр 23 хувиар буурч, 2.5 тэрбум төгрөг болжээ. “Баянгол зочид буудал” компани 22 жил хувьцаа эзэмшигчдэд хувь олгож байгааг Монголын Хөрөнгийн бирж мэдээлсэн юм. Хамгийн сүүлд 2016 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаанд 355 төгрөгийн ногдол ашиг тараасан байна. Нийт 150.2 сая төгрөгийг тараасан нь 2016 оны цэвэр ашгийн 4.6 хувьтай тэнцжээ. Дөрвөн одны зэрэглэлтэй “Баянгол зочид буудал” 211 өрөөтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компанийн хувьцааны ханш жилийн дүнгээр 16.3 хувиар буурч, 34,000 төгрөг болоод байна.

Одоогоор Монгол Улсад олон улсын сүлжээ болон дотоодын хөрөнгө оруулалттай 532 зочид буудал үйл ажиллагаа явуулж байгааг Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Эдгээрээс 81 зочид буудал II-V одны шаардлага хангажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Анд энерги”-ийн цэвэр ашиг 121.4 сая төгрөгт хүрлээ

Лед гэрэл үйлдвэрлэгч “Анд энерги” компанийн борлуулалтын орлого 2017 онд 944.3 сая төгрөг болж, цэвэр ашгийн хэмжээ 121.4 сая төгрөгт хүрлээ. Борлуулалтын орлогын 60.2 хувийг лед гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэлийн орлого эзэлж байгааг тайландаа тусгасан байна. Харин үлдсэн 39.8 хувийг цахилгаан тоног, төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээ, үйлдвэрлэлийн автоматжуулалтын ажлын орлого бүрдүүлжээ. Тус компани цаашид жил бүр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд тохирсон гурваас доошгүй шинэ бүтээгдэхүүнийг гаргахаар төлөвлөж байгаа юм байна. Мөн олон улсын стандартад нийцүүлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр 2018-2021 онд дотоодын гэрлийн зах зээлийн таван хувийг хангах зорилго тавин ажиллаж байгааг “Анд энерги” компани онцоллоо. Тус компани жил бүрийн цэвэр ашгийн 5-8 хувийг ногдол ашигт хуваарилахад болсон байна. Цаашид ногдол ашигт хуваарилах цэвэр ашгийн хувь хэмжээг жил бүр тогтмол нэмэгдүүлэх бодлого баримтлах ажээ.

“Анд энерги” компани 2017 оны 11 дүгээр сард IPO гаргаснаас хойш 73 удаагийн арилжаагаар 100 гаруй сая төгрөгийн гүйлгээ хийгдээд байгааг Монголын Үнэт цаасны бирж мэдээллээ. “Анд энерги”-ийн хувьцааны ханш сүүлийн гурван сар гаруйн хугацаанд 26.7 хувиар унаад байна. Ингэснээр сүүлийн байдлаар нэгж хувьцаа нь 44 төгрөг болжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Fitch: Монголын Алт Корпорацийн бонд гаргах явц хойшилсон

Монголын Алт Корпораци Европын сэргээн босголт хөгжлийн банк болон Германы Хөрөнгө оруулалтын корпорациас авсан зээлийн хэлцлийнхээ дуусгавар болох хугацааг хоёрдугаар сарын 28-наас гуравдугаар сарын 31 хүртэл сунгасан талаар “Fitch” агентлаг мэдээллээ. Мөн тус компанийн бонд гаргах явц хойшилсныг “Fitch” дурдсан байна. Монголын Алт Корпораци бонд гаргах замаар 200 сая ам.доллар босгож, эдгээр зээлээ бүтнээр нь эргүүлэн төлөхөөр төлөвлөж байгааг мэдэгдэлд онцолжээ. Хэдий тийм боловч зээлийн хэлцлийн хугацаагаа сунгасан нь тус компанийн зээлжих зэрэглэлийг “ССС+” түвшинд тогтоохоор төлөвлөж байгаа “Fitch”-ийн үнэлгээнд нөлөөлөхгүй гэж үзсэн байна. Харин бусад зээлдэгч тухайлбал “ЕК-F”-тэй байгуулсан зээлийн хэлцэл тавдугаар сарын 31-нд, Хөгжлийн банкнаас авсан зээлийн хугацаа ирэх зургаадугаар сарын 30-нд дуусгавар болох ажээ. Мөн “ЕК-F”-тэй байгуулсан зээлийн хэлцлийн дагуу Монголын Алт Корпораци шинэ бонд гаргах асуудлаа гуравдугаар сарын 31 гэхэд эцэслэсэн байх шаардлагатай байгааг “Fitch”-ийн шинжээчид онцолж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

“Ногоон Хөгжил Үндэсний Нэгдэл” ХК-ийн үнэт цаасыг бүртгэлийн ангилал ахиуллаа

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн II ангиллын шалгуур шаардлагыг хангаж байгаа “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийг “Бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйлийн 20.2, 20.3.1 заалт болон компаниас ирүүлсэн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 17/02 тоот ангилал ахиулах тухай хүсэлтийг үндэслэн бүртгэлийн “II” ангиллаас ахиулан “II” ангилалд бүртгэхээр боллоо.

Эх сурвалж: MSE

Хувьцааны багцын арилжааны үнийн дүнгийн хэмжээг өөрчиллөө

Зах зээлийн оролцогчдоос ирүүлсэн хүсэлтийн дагуу хувьцааны багцын арилжааны үнийн дүнгийн доод хэмжээг 250.0 сая төгрөг байсныг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/32 дугаар тушаалын дагуу 100.0 сая төгрөг болгон өөрчлөлт орууллаа. Багцын арилжааны үнийн дүнгийн өөрчлөлтийг 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Эх сурвалж: MSE

Goldman Sachs: АНУ-ын ЗГ-ын бондын өгөөж 4.5 хувьд хүрвэл хувьцааны зах зээлд уналт үүсэж магадгүй

АНУ-ын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж энэ оны эцэс гэхэд 4.5 хувьд хүрвэл эдийн засаг, цаашлаад хөрөнгийн зах зээлд уналт үүсэж магадгүй гэж “Goldman Sachs” мэдэгдлээ. Тодруулбал, хувьцааны зах зээл 20-25 хувиар унаад зогсохгүй, эдийн засагт удаашрал үүснэ гэж тус банкны шинжээчид үзэж байгаа ажээ. Хэдий тийм боловч “Goldman Sachs”-ийн тооцоолж байгаагаар 2018 оны эцэс гэхэд АНУ-ын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж 3.25 хувьд хүрнэ гэж харж байгаа юм. Хоёрдугаар сард хөрөнгийн зах зээлд уналт үүссэн нь АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж гурван хувьд хүрнэ гэсэн болгоомжлолтой холбоотой гэж зарим эдийн засагчид тайлбарлажээ. Хэрвээ хувьцааны зах зээл 20-25 хувиар буурвал “S&P 500” индекс нэгдүгээр сарын 26-ны дээд цэгээс доошилж, 2155-2298 нэгж орчимд хэлбэлзэнэ гэж таамаглаж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ түүхэн дээд түвшинд хүрчээ

Үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоод өнгөрсөн онд 25 хувийн өсөлт үзүүлээ хэмээн Санхүүгийн зохицуулах хорооноос мэдээллээ.

Дээрх салбаруудыг СЗХ зохицуулдаг бөгөөд үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2017 оны жилийн эцэст 2.4 их наяд төгрөгт хүрсэн нь 2016 оноос 65.9 хувийн өсөлт үзүүлсэн нь түүхэндээ хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. Зах зээлийн үнэлгээг дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулбал 9 хувьд хүрчээ. Улмаар үнэт цаасны шинээр гаргасан үнэт цааснууд амжилттай арилжигдсан нь тус салбарт зах зээлийн эрэлт нэмэгдснийг илтгэжээ.

Тодруулбал өнгөрсөн онд үнэт цаасны нийт арилжаа 860.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд хувьцааны арилжаа 78.1 тэрбум, Засгийн газрын үнэт цаасны арилжаа 772.5 тэрбум, компанийн бондын арилжаа 10.2 тэрбум төгрөг байсан. “Монголын хөрөнгийн бирж” ХХК-ийн ТОП-20 индекс 66.5 хувиар, MSE-ALL индекс 33.1 хувиар өсчээ.

Хөрөнгийн зах зээлд нийт 52 үнэт цаасны компани болон Хорооны үнэт цаасны бүртгэлд бүртгэлтэй 300 хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна.

Хөрөнгийн зах зээлийн өсөлтөд жин дарсан гол арилжаа бол ЗГҮЦ-ны арилжаа юм. Мөн онд анхдагч зах зээлийн арилжаагаар 6.7 сая ширхэг үнэт цаасыг 630.2 тэрбум төгрөгөөр арилжиж, харин ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 1.4 сая ширхэг үнэт цаасыг 142.3 тэрбум төгрөгөөр арилжжээ.

Эх сурвалж: Montsame.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Монголбанкны алт худалдан авалт 47.4 хувиар буурав

Монголбанк хоёрдугаар сард 390 кг алт худалдан авсан хэмээн мэдээллээ.

Түүрх жилийн өдийд 741 кг алт худалдан авч байсан Төвбанк энэ удаад 390 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 47.4 хувиар буурсан үзүүлэлт гарлаа.

Алт худалдан авалт ийнхүү буурсан нь Лондонгийн үнэт металлын захын алтны ханш саарч, улмаар Монголбанкны алт худалдан авах үнэ болон алт олборлолтын хэмжээ буурснаас үүдэлтэй хэмээн мэргэжилтнүүд онцолж байна. Нэг грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 102 мянга 833 төгрөг 87 мөнгө байна.

Эх сурвалж: Montsame.mn



Засгийн газрын хуралдаанаар түүхий нүүрсний хэрэглээг хориглохоор болов

Засгийн газрын хуралдаан болж ирэх оны тавдугаар сарын 15-ны өдрөөс Улаанбаатар хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэр гаргалаа.

Энэ шийдвэр Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудад хамаарахгүй юм. Сайжруулсан түлшний эрэлт, нийлүүлэлт, үнийн тэнцвэртэй байдлыг хангах асуудлыг судалж ирэх долоодугаар сарын нэгний дотор шийдвэр гаргахыг холбогдох сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгав.

Нийслэлчүүдийн хэрэглэж байгаа түүхий нүүрсний одоогийн хэрэгцээг 600 мянган тонн шахмал түлшээр солих бүрэн боломжтой гэж үзэж байна. Халаалтын улиралд 4-5 тонн түүхий нүүрс хэрэглэдэг нэг өрх гурван тонн шахмал түлш хэрэглэнэ гэсэн үг юм. Энэ нь эдийн засгийн хувьд ч тухайн өрхөд ашигтай. Тухайлбал Налайхын таван тонн нүүрсийг /тонн нь 170 мянган төгрөг/ 850 мянган төгрөгөөр худалдан авах бол гурван тонн шахмал түлш /тонн нь 220 мянган төгрөг/-ийг 660 мянган төгрөгөөр авснаар 190 мянган төгрөг хэмнэх тооцоо гарчээ. Түүхий нүүрсний хэрэглээг хориглож сайжруулсан шахмал түлшээр хангаснаар хорт утааны ялгарал их хэмжээгээр буурч, агаарын бохирдол эрс багасна гэж Засгийн газар үзэж байна. Гэр хорооллын 202 мянган өрх жилдээ 1.1 сая тонн түүхий нүүрс түлдэг бөгөөд ялгарч байгаа утаа нь агаарын бохирдлын 80 гаруй хувийг бүрдүүлдэг юм.

Эх сурвалж: Montsame.mn

Улс төрийн тодорхойгүй байдал Монгол Улсын металлын экспортод нөлөөлөх үү

Улс төрийн тодорхойгүй байдал, металлын ханшийн савлагаа БНХАУ-д хийх Монгол Улсын экспортод нөлөөлнө гэж "Bloomberg Intelligence"-ийн шинжээчид үзэж байна. Ялангуяа хөрш орнуудтайгаа харилцах Монгол Улсын харилцаа БНХАУ-д хийх металлын экспортод нөлөөлж магадгүй байгаа аж. "Bloomberg"-ийн шинжээчдийн урьдчилсан тооцоогоор энэ онд БНХАУ-ын импорт буурч, үйлдвэрлэлийн салбарын үнэ төдийлөн сэргэхгүй гэж тооцоолсон байна. Мөн агаарын бохирдлын эсрэг арга хэмжээ эрчимжиж, үл хөдлөх хөрөнгийн салбар удаахрах төлөвтэй байгаа нь дотоодын эрэлтэд сөргөөр нөлөөлж магадгүй байгааг "Bloomberg"-ийн шинжээчид онцолжээ. Хоёрдугаар сард БНХАУ-ын зах зээлд металлуудын ханш нэлээд тогтворгүй, холигдмол дүр зурагтай байсан аж. Тухайлбал, ган, төмрийн хүдрийн ханш өсөлттэй байсан бол бусад голлох металлуудад уналт давамгайлж байжээ.

Эх сурвалж: Bloomberg.Tv.mn

TRQ: 2018-2025 онд "Оюу Толгой"-ийн зэсийн гарц 340 хувиар, алтны гарц 150 хувиар өснө

Торонто болон Нью-Йоркийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Turquoise Hill Resources" компани "BMO Global Metals and Mining Conference"-ийн үеэр "Оюу Толгой" төслийн талаар танилцуулга хийсэн байна. Олон улсын хэмжээнд гурав дахь том зэсийн уурхай болох төлөвтэй байгаа "Оюу Толгой" төслийн зэсийн гарц 2018-2025 онд 340 хувиар өснө гэж тооцож байна. Мөн хугацаанд алтны гарц 150 хувиар өснө гэж "Turquoise Hill Resources" мэдээллээ. Үүнээс гадна 2014-2017 оны III улирал хүртэлх хугацаанд "Оюу Толгой"-ийн төслийн үйл ажиллагааны бэлэн мөнгөний урсгал хоёр тэрбум ам.долларт хүрсэн байна. Харин 2022-2026 онд чөлөөт мөнгөн урсгал 9.5 тэрбум ам.доллар болно гэж тооцжээ. 2025 онд "Оюу Толгой"-ийн бүтээгдэхүүний гарц оргил үедээ хүрэх хүлээлттэй байгаа юм. Харин 2017-2025 он хүртэл цахилгаан автомашины хэрэглээнээс хамаарч үүсэх зэсийн эрэлт ойролцоогоор зургаа дахин нэмэгдэнэ гэж "Turquoise Hill Resources"-ийн танилцуулгад дурджээ. "Оюу Толгой"-ийн хөрөнгө оруулагч "Rio Tinto" компанийн тухайд зарим хөрөнгөө худалдсанаар 2018 онд таван тэрбум гаруй ам.долларын хөрөнгө босгож магадгүй гэж "UBS" банк мэдээллээ. Компани "Pacific Aluminum"-ийн нэгжээ худалдсанаар 1.8-2.3 тэрбум ам.доллар хүлээн авах, Канадын "Iron Ore Company"- аас 1.3-1.6 тэрбум ам.доллар, "Grasberg"-ийн алт, зэсийн төсөл дэх хувиасаа 3.8 орчим тэрбум ам.долларын хөрөнгө татах боломжтой гэж шинжээчид тооцоолж байна.

Үүнээс гадна "Rio Tinto" Оман дахь "Sohar"-ийн хайлуулах үйлдвэр дэх хувиа худалдах боломжийг эрэлхийлж магадгүй байгаа аж. Тийм учраас "Rio Tinto" компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах 2.7 тэрбум ам.долларын хөтөлбөрөө нэмэгдүүлэх, мөн наймдугаар сард хагас жилийн үзүүлэлтээ гаргах үеэр онцгой ногдол ашиг олгох боломжтой болж магадгүй гэж "UBS" банк үзлээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

"Оюутолгой" 861.5 сая төгрөгийн нөхөн татвар, торгуулийг улсын төсөвт төлнө

Гаалийн байгууллагаас "Оюутолгой" ХХК-д хийсэн бүрдүүлэлтийн дараах шалгалтын үр дүн болон тус компанид тавьсан Гаалийн улсын байцаагчийн актыг Оюутолгой ХХК үл зөвшөөрч өнгөрсөн оны хоёрдугаар сард Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан билээ. Тэгвэл Нийслэл дэх захиргааны хэргийн болон давах шатны шүүхээс Гаалийн байгууллагаас шалгаж хууль зүйн бүрэн үндэслэлтэй гэж дүгнэсэн байна.

Тодруулбал уг захиргааны хэрэг нь Монгол Улсын Дээд Шүүхээр хянагдаж, тус шүүхээс давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээхээр эцэслэн шийдвэрлэжээ.

Ингэснээр "Оюутолгой" ХХК 2013-2015 онд БНХАУ-аас худалдан авсан цахилгаан эрчим хүчний гаалийн үнэд нэмэгдэж тооцох нийт 13.2 тэрбум төгрөгийн зардалд 861.5 сая төгрөгийн нөхөн татвар, торгуулийг улсын төсөвт төлөхөөр болж байна. Мөн цахилгаан эрчим хүч худалдан авахтай холбоотой зардалд тус компани жил бүр 1-1.5 орчим тэрбум төгрөгийг улсын төсөвт нэмж төлөхөөр болж буйг ГЕГ-аас мэдэгдлээ.

Эх сурвалж: Montsame.mn

Монгол Улс бичил уурхайн мэдээллийг нэгтгэсэн цахим платформтой болов

Байгаль орчинд ээлтэй нийгэмд сайн жишиг тогтоох бичил уурхайг хөгжүүлэхэд Швейцарийн Хөгжлийн агентлагийн "Тогтвортой бичил уурхай" төсөл Монгол Улсад 13 дахь жил хувь нэмрээ оруулж байна. Дээрх төслийн дөрөв дэх шатны хэрэгжилтийн хүрээнд "Бичил уурхайн мэдлэгийн төв"-ийн цахим платформ бий болгожээ.

"Тогтвортой бичил уурхай" төслөөс бичил уурхайг албажуулахад хувь нэмрээ оруулах дээрх цахим платформ УУХҮЯ-нд 3-р сарын 1-нд албан ёсоор хүлээлгэн өглөө. Энэхүү "Бичил уурхайн мэдлэгийн төв"-ийн цахим платформ салбарын яам ажлын алба байгуулан цааш нь хөгжүүлж авч явах юм байна.

Эх сурвалж: Montsame.mn

БУСАД МЭДЭЭ

Дональд Трамп ган, хөнгөн цагааны импортод гаалийн тариф тогтоохоор шийдвэрлэлээ

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп ган, хөнгөн цагааны импортод гаалийн тариф тогтоохоор шийдвэрлэсэн байна. Түүний хувьд шударга бус худалдааны бодлогын нөлөөгөөр АНУ сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээний хохирол хүлээсэн гэж шүүмжилдэг. Улмаар үндэсний аюулгүй байдлаа хангах, дотоодын компаниудаа дэмжих зорилгоор гангийн импортод 25 хувь, хөнгөн цагааны импортын бүтээгдэхүүнд 10 хувийн тариф тогтоохоор шийдвэрлэжээ. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп "Бид ган, хөнгөн цагааны импортод гаалийн тариф тогтоох болно. Ирэх долоо хоногт шийдвэрт гарын үсэг зуран, эцэслэн батална гэж харж байна. Ийнхүү зарим металлуудад тариф тогтоосноор таатай үр дүн гарах болно. Тухайлбал, шинээр ажлын байрууд бий болж, АНУ-ын металлургийн компаниудын үйл ажиллагаа илүү эрчимжинэ. Сайн зүйл гэж би харж байгаа. Дахин хэлэхэд сүүлийн хэдэн 10 жилийн турш энэ үйл явцыг үргэлжлүүлсээр байсныг хүлээн зөвшөөрч болохгүй. Тиймээс бид дотоодын компаниудаа хамгаалж, энэ шийдвэрийг гаргах шаардлагатай юм" гэж мэдэгдсэн байна.

Хэрвээ Дональд Трампын энэ шийдвэр амжилттай хэрэгжвэл АНУ-ын гангийн гарцыг нэмэгдүүлж, металлургийн нүүрсний эрэлтийг 10 хувиас дээш хувиар өсөхөд хүргэж магадгүй гэж "Clarksons Platou Securities"-ийн шинжээчид үзэж байна. Хэдий тийм боловч энэ нь тарифын бүтцээс хамаарна гэдгийг тус компани онцолжээ.

АНУ-ын засаг захиргаа зарим импортын металлуудад гаалийн татвар ногдуулахаар шийдвэрлэсэн нь АНУ-д автомашины үнийг өсгөнө гэж "Toyota" компани үзэж байгаа юм. Үүнээс гадна энэхүү шийдвэр АНУ-ын автомашин үйлдвэрлэлийн салбарт сөргөөр нөлөөлж, автомашины борлуулалтыг бууруулах өндөр магадлалтай гэдгийг "Bloomberg"-ийн шинжээчид онцолж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

Жером Пауэлл: Энэ онд бодлогын хүүг дөрвөн удаа өсгөж магадгүй

"АНУ-ын эдийн засаг өсөж байгаагаас гадна инфляци хоёр хувийн зорилтот түвшинд хүрнэ гэдэгт итгэх итгэл нэмэгдсэн" гэж Холбооны Нөөцийн банкны шинэ тэргүүн Жером Пауэлл мэдэгдэв. Тэрбээр албан үүргээ хүлээн авсныхаа дараа анх удаа Конгрессын өмнө буюу олны өмнө мэдэгдэл хийлээ. АНУ-ын Төв банкны шинэ тэргүүн Жером Пауэлл "АНУ-ын Төв банк өнгөрсөн 12 дугаар сард хийсэн хурлаар бодлогын хүүг энэ онд гуравн удаа өсгөнө гэсэн таамаг гаргаж байсан. Харин энэ таамаг эрхэн өөрчлөгдөх нь гуравдугаар сард тодорхой болно. Тодорхой байгаа зүйл нь эдийн засаг өсөж байгаа тоон үзүүлэлтүүд гарч байна. Хөдөлмөрийн зах зээл улам сайжирч байна. Зарим тоон үзүүлэлтээс инфляци зорилтот түвшинд хүрч өснө гэдэгт итгэх итгэл нэмэгдсэн. Олон улсын хэмжээнд ч бас эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг сайн дүнтэй байна. АНУ-ын төсвийн бодлогоор эдийн засаг дахь мөнгөний эргэлт нэмэгдэхээр байгаа тул цаашид мөнгөний бодлогын чиглэл өнгөрсөн 12 дугаар сард гарсан дүгнэлтээс өөрчлөгдөнө гэж бодож байна. Бодлогын зөвлөл гуравдугаар сард хуралдана. Одоогоор урьдчилсан дүгнэлт хиймээргүй байна" гэж мэдэгдлээ.

Жером Пауэллийн мэдэгдэл АНУ-ын Төв банк цаашид ямар бодлого баримтлах талаар тодорхой мэдээлэл өгөөгүй. Гэхдээ тус банк энэ онд бодлогын хүүгээ гурав биш дөрвөн удаа өсгөх хүлээлт эдийн засагчдын дунд улам нэмэгджээ. Тухайлбал, гуравдугаар сард бодлогын хүүг өсгөх магадлал 100 хувьтай байгааг "Bloomberg"-ийн шинжээчид онцолж байна. АНУ-ын татварын шинэчлэл, төсвийн бодлогоос хамаарч эдийн засаг дахь мөнгөний эргэлт нэмэгдэх төлөвтэй байгаа юм. Үүнээс хамаарч Холбооны Нөөцийн банк мөнгөний бодлогоо өсгөх чиглэл давамгайлж байгааг шинжээчид хэлж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



Хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах талаар онцгой анхаарч ажиллана

Монгол Улсын ГХЯ Д.Цогтбаатар Монголын бизнесийн зөвлөл (МБЗ)-ийн гишүүн байгууллагууд болон хөрөнгө оруулагчдад зориулсан сар бүрийн уулзалтад оролцож, "Худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх болон 2018 оны боломжууд" сэдвийн хүрээнд гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад худалдааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн үр дүн, цаашдын зорилтын талаар танилцуулж, санал бодлоо солилцлоо.

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Монгол Улсын Засгийн газраас сүүлийн жил хагас гаруйн хугацаанд авч хэрэгжүүлсэн эдийн засгаа сэргээх, төрөлжүүлэх, макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой бодлогын арга хэмжээ, түүний үр дүнд эдийн засгийн уналт, сааралт тогтворжиж, 2017 онд эдийн засгийн өсөлт 5.1 хувьд хүрээд байгаа болон Дэлхийн банк, Олон улсын валютын сан зэрэг олон улсын банк санхүүгийн байгууллагууд Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2018-2020 онд 4-8 хувь байх боломжтой гэсэн таамаглал гаргасныг дурдав.

Мөн Монгол Улсын гадаад худалдааны эргэлт 2017 оны байдлаар 10,5 тэрбум ам долларт хүрч 27,3 хувиар, манай экспортын хэмжээ 6,2 тэрбум ам долларт хүрч өнгөрсөн оны экспортоос 26,1 хувиар тус тус өссөн тухай, түүнчлэн эдийн засгийн зөв, тууштай бодлогын үр дүнд гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэх хандлагатай болж, манай улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2017 оны жилийн эцсийн байдлаар 1,3 тэрбум ам. долларт хүрч өссөн, үүний үр дүнд манай улсын гадаад валютын нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш тогтворжсоныг цохон тэмдэглэв.

Тэрбээр цаашид ч Засгийн газрын зүгээс бизнес эрхлэгчдэд ус, агаар мэт шаардлагатай хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, тогтвортой байдлыг хангах талаар онцгой анхааран ажиллахаа мэдэгдэж, эдийн засгийг төрөлжүүлэх, ингэхдээ уул уурхайн бус салбарт үйл ажиллагаа эрхэлдэг жижиг дунд үйлдвэрлэгчдийг тодорхой бодлогын дагуу дэмжих тухай байр суурийг илэрхийлэв.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдлаар баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.